

## ЛИНФИЛДИЙН ТЭТГЭЛЭГ БОЛОН ТУСГАЙ ШАГНАЛ, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Гаргасан амжилт дээр суурилсан тэтгэлгийг элсэлтийн өргөдөлд тусгасан боловсролын чадварт үндэслэн олгодог. Гаргасан амжилт дээр суурилсан тэтгэлэгт хамрагдахын тулд тусдаа өргөдөл гаргах шаардлагагүй. Элсэлтийн өргөдөл гаргах эцсийн хугацааг (2-р сарын 1) хангасан оюутнуудыг гаргасан амжилт суурилсан тэтгэлэгт хамруулна.

Линфилдийн Тэтгэлэг болон Амралтын өдрийн сургуулийн айлчлал (манай кампус болон шалгалтад суурилсан тэтгэлэгт хөтөлбөр)-д уригдахыг сонирхож буй оюутан 12-р сарын 01-ний дотор элсэх хүсэлтээ гаргаж, Коммон Аппликейшн (<https://www.commonapp.org>) дээр ямар шалгалтад орох сонирхолтой байгаагаа тусгаж өгөх ёстой.

Оюутан нь Холбооны оюутны тусламжийн үнэ төлбөргүй өргөдөл буюу FAFSA® (<https://studentaid.gov/h/apply-for-aid/fafsa>)-ийг бөглөсөн тохиолдолд оюутны холбооны болон мужийн буцалтгүй тусламж, холбооны оюутны зээл, оюутны ажил эрхлэлт зэрэг **нэмэлт санхүүгийн тусламж авах боломжтой** эсэхийг Линфилд хянана.

ЛИНФИЛД НЬ БҮТЭН ЦАГААР СУРАЛЦДАГ НЭГДҮГЭЭР ДАМЖААНЫ ОЮУТНУУДАД ЗАРИМ ТӨРЛИЙН БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГ ОЛГОХ ТЭТГЭЛЭГТ САНАЛ БОЛГОДОГ.

### ТЭТГЭЛГҮҮД НЬ:

- Зөвхөн бакалаврын сургалтанд зориулагдсан
- Шаардлага хангасан оюутны бүтэн цагийн хичээлд хамрагдсан ирцийн эхний 8 семестрийн хугацаанд семестр тутам олгодог (семестр тус бүрт дор хаяж 12 кредит цаг)
- Санхүүгийн хэрэгцээнээс үл хамааран олгодог

Шаардлага нь ахлах сургуулийн 3.20 голч онооноос эхэлдэг бөгөөд элсэлтийн үеэр тодорхойлогддог. Бүх гаргасан амжилтад суурилсан тэтгэлгийг нэн тэргүүнд хэлэлцэхийн тулд таны элсэлтийн өргөдлийг **аль болох зарлагдсан хугацааны эхэнд** бөглөж ирүүлсэн байх ёстой. Нэмж дурдахад оюутнууд тэтгэмжээ сунгахын тулд **Satisfactory Academic Progress (SAP)**-ийг хангасан байх ёстой.

### ЛИНФИЛДИЙН АКАДЕМИК ТЭТГЭЛЭГТ АВАХ БОЛОМЖ

Линфилдийн анхны тэтгэлэг

Линфилдийн анхны тэтгэлэг нь коллежийн нэгдүгээр үеийн оюутнуудад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх, оюутны хотхонд хүмүүжүүлэх ур чадвар болон туршлагыг нь өрдөн цогцлоох зорилготой юм. Линфилд нь эцэг эх нь бакалаврын зэрэг төгсөөгүй, ЭСВЭЛ бакалаврын зэрэг төгсөөгүй ганц бие эцэг/эхтэй өрх толгойлсон гэр бүлээс бакалаврт суралцахаар элссэн анхны оюутныг "нэгдүгээр үе" гэж тодорхойлдог.

**Элсэлтийн үеэр Линфилд Анхны Тэтгэлэгт** хамруулах эсэхийг хянан хэлэлцэнэ.

Энэхүү тэтгэлэг нь бүтэн цагаар суралцаж буй нэгдүгээр дамжааны оюутнуудад зориулагдсан болно.

Оюутан сурлагын ахиц дэвшил гаргасан тохиолдолд Линфилдийн анхны тэтгэлгийг автоматаар сунгах боломжтой.

### Хөгжмийн тэтгэлэг

**Хөгжмийн тэнхим** нь бүтэн цагаар суралцдаг оюутнуудад сонгон шалгаруулалт явуулж хоёр төрлийн тэтгэлэг санал болгодог:

- Хөгжмийн мэргэжлийн болон сонирхогчдод зориулсан Хөгжмийн Амжилтын Шагнал
- Мэргэжлийн, сонирхогчид болон мэргэжлийн бус хүмүүст зориулсан Хөгжмийн Оролцооны Шагнал

Сонгон шалгаруулалт явуулснаар Хөгжмийн тэнхим нь хөгжимд амжилттай оролцсон оюутнуудыг таних, тэдэнд тэтгэлэгт хамрагдахад туслалцаа үзүүлэх боломжийг олгодог. Шаардлагыг хангаж буй өргөдөл гаргагчид элсэлтийн өргөдөл гаргасан байх ёстой.

### Хөгжмийн Амжилтын Шагнал:

Жил тутам \$5,000-\$6,000 хооронд хэлбэлздэг бөгөөд эдгээр нь хөгжмийн үзүүлбэрт тасралтгүй оролцох болон Хөгжмийн тэнхимийн зөвлөмжид үндэслэн шинэчлэгдэх боломжтой.

Сонирхсон оюутнууд 2-р сарын 15-ны дотор биечлэн эсвэл CD/DVD-ээр шалгаруулалтад оролцох шаардлагатай.

Хөгжмийн Амжилтын Шагналууд нь Хөгжмийн тэнхимээс олгодог Линфилдийн Өрсөлдөөнт Тэтгэлгээс ялгаатай, тусдаа тэтгэлэг бөгөөд оюутнуудыг хоёуланд нь өргөдөл гаргахыг зөвлөдөг.

Хөгжмийн чиглэлээр мэргэшэх болон сонирхлоороо суралцахаар төлөвлөж буй оюутнуудыг Хөгжмийн Амжилт болон Оролцооны Шагналд хоёуланд нь авч хэлэлцэнэ.

#### **Хөгжмийн Оролцооны Шагнал:**

Хөгжмийн Оролцооны Шагнал нь Хөгжмийн тэнхимийн зөвлөмжид үндэслэн хөгжмийн өвөрмөц авьяастай оюутнуудад зориулан жил тутам \$2,000 олгодог.

Хөгжмийн чиглэлээр мэргэшсэн болон сонирхлоороо суралцахаар төлөвлөөгүй оюутнуудыг зөвхөн Хөгжмийн Оролцооны Шагналд л хянан хэлэлцэнэ.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Линфилдийн [Хөгжмийн тэнхимтэй](#) холбоо барина уу. Хөгжмийн Амжилтын Шагналыг зөвхөн Макминнвилл кампуст суралцаж буй оюутнууд авах боломжтой бөгөөд хэрэв оюутан Портлэндийн кампус руу шилжсэн тохиолдолд нөхөн олгохгүй гэдгийг анхаарна уу.

#### **Линфилд их сургуулийн бусад тэтгэлгийн талаар эндээс үзнэ үү:**

<https://www.linfield.edu/financial-aid/incoming-students/mcminnville-students/first-year-scholarships.html>

#### **Линфилд их сургуульд элсэх өргөдөл гаргах:**

[https://linfield.edu/admission/index.html?\\_ga=2.3222064.1009712080.1648004709-1911959184.1648004709](https://linfield.edu/admission/index.html?_ga=2.3222064.1009712080.1648004709-1911959184.1648004709)

### **ЛИНФИЛДИЙН ШАГНАЛУУД, ТЭТГЭЛГҮҮД, БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖУУДЫН ЯЛГАА**

#### **АВЬЯАСЫН ШАГНАЛ**

Театр, шүүх эмнэлэг, сэтгүүл зүйн үйл ажиллагааны чиглэлээр өвөрмөц авьяастай, бүтэн цагийн бакалаврын оюутнуудын хэрэгцээнд үндэслэн олгогддог.

#### **ЛИНФИЛДИЙН ИХ СУРГУУЛИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ**

Эдгээр тэтгэлэгийг санхүүгийн хэрэгцээнд үндэслэн бүтэн цагийн бакалаврын оюутнуудад олгодог. Линфилдийн Их сургуулийн Тэтгэлэг нь санхүүгийн хэрэгцээ шаардлага байгаа оюутанд есөн семестрийн турш олгогдоно.

#### **ОЛОН УЛСЫН ОЮУТНУУДАД ЗОРИУЛСАН ТЭТГЭЛЭГ БОЛОН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ**

Хязгаарлагдмал тооны тэтгэлэг, буцалтгүй тусламжийг олон улсын бакалаврын бүтэн цагийн оюутнуудад олгох боломжтой. Өргөдөл гаргагч бүрийг өмнөх сурлагын амжилт, санхүүгийн хэрэгцээ шаардлага, Линфилдийн кампус болон олон нийтийн амьдралд оруулсан хувь нэмрийг харгалзан тус тусад нь авч хэлэлцдэг.

#### **ХАНДИВЫН БОЛОН ТУСГАЙ ТЭТГЭЛГҮҮД**

Хандивын болон бусад тэтгэлгүүд нь коллежийн найзуудын өгөөмөр сэтгэлээр цугларсан мөнгөн хандиваас бүрдэх боломжтой оюутнуудын санхүүгийн тусламжийн эх үүсвэр юм.

Тэтгэлгүүд нь онцгой хүний дурсгалыг хүндэтгэх, өргөмжлөхөд зориулж хандивласан хөрөнгийн сангийн жилийн орлогоос олгогддог. Төгсөгчид болон Линфилдтэй ойр дотно холбоотой бусад найзуудын тусламжтайгаар эдгээр тэтгэлгүүд бодит болсон. Тэтгэлэг хүлээн авагчид хэзээ нэгэн цагт бусдад туслахаар шийдэж хойч үедээ ашиг тусаа өгөхийн тулд иймэрхүү тэтгэлгийг үргэлжлүүлнэ гэдэгт итгэдэг.

Эдгээр тэтгэлэгт хамрагдахын тулд тусдаа өргөдлийн маягт шаардлагагүй. Санхүүгийн тусламжтай холбоотой хандивлагчдын хүсэл болон коллежийн бодлогын дагуу Санхүүгийн тусламж хүсэж өргөдөл гаргасан бүх оюутнуудыг тэтгэлэг тус бүрт автоматаар авч хэлэлцдэг.

Хэзээ нэгэн цагт Линфилд нь Линфилдийн Тэтгэлэг эсвэл Линфилд Их сургуулийн Буцалтгүй тусламжийг эдгээр сангуудаар сольж магадгүй юм.